



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан*



**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН
ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот
2014 он

Агуулга

<p>Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт</p>	<p>2</p>
<p>НАГ-ын Дарга <i>Б.Алтанзул</i> Аудитын менежер <i>З.Ариунзаяа</i></p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл</p>	<p>3</p>
<p>Шинжээч <i>Б.Билэгт</i></p>	<p>Бүлэг 1. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн талаар</p>	<p>5</p>
	<ul style="list-style-type: none"> • АСТС-ийн 2013 оны төлөвлөгөөг боловсруулж батлаагүй байна 	<p>5</p>
	<p>Бүлэг 2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар</p>	<p>6</p>
	<ul style="list-style-type: none"> • Архидан согтуурахтай тэмцэх сангийн 2013 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан гараагүйгээс сангийн үйл ажиллагааны үр дүнг тооцох боломжгүй байна..... 	<p>8</p>
	<p>Бүлэг 3. Сангийн удирдлага болон хяналтын талаар</p>	<p>9</p>
	<ul style="list-style-type: none"> • АСТС-ийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд ХЗЯ-аас дотоод хяналт хийгээгүй байна..... 	<p>9</p>
	<p>Дүгнэлт</p>	<p>10</p>
<p>2014 оны 10 дугаар сар</p>	<p>Холбогдох байгууллагын санал</p>	<p>11</p>
<p><i>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn</i></p>	<p>Зөвлөмж</p>	<p>14</p>
<p><i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i></p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал ...</p>	<p>15</p>
<p>ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i></p>		

Товчилсон үгийн жагсаалт

АСТС	Архидан согтуурахтай тэмцэх сан
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол Улс
НАГ	Нийцлийн аудитын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЗЯ	Хууль зүйн яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 3 дугаар тогтоол, ҮАГ-аас МУ-ын Ерөнхий Аудитор 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

АСТС-гийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалт зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт үр нөлөөтэй эсэх

Хамарсан хүрээ

Аудитад ХЗЯ-ны Архидан согтуурахтай тэмцэх сангийн ажлын алба, тухайн төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- АСТС-гийн орлогын бүрдүүлэлтийг түүвэрлэн шалгалаа,
- Холбогдох эрхийн актыг судлав,
- АСТС-гийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийсэн,
- АСТС-гаас бараа, ажил үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу худалдан авсан эсэхийг түүвэрлэн шалгасан болно.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Хууль зүйн сайдын багцад АСТС-ийн 2013 оны үйл ажиллагаанд зориулж 674.5 сая төгрөг батлагджээ.

Архидан согтуурахтай тэмцэх сан нь Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор баталсан АСТС-ийн дүрмийн 2 дугаар заалт “Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт” нь дараах эх үүсвэрээс бүрддэг байна.

2.2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13² дугаар зүйлийн 13².4-т “Сангийн үйл ажиллагаанд шаардлагатай үед төрөөс дэмжлэг үзүүлж болно” гэж заасныг үндэслэн дараахь үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар санхүүжүүлдэг байна. Үүнд:

2.2.1. архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архины хор уршгийг бууруулах талаар улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ;

2.2.2. архидан согтуурснаас олон нийтэд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тогтоох судалгаа, шинжилгээний ажил;

2.2.3. архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын оролцоог дэмжих;

2.2.4. архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг судалж, архины хамааралтай сөрөг зан үйлд нь нөлөөлөх, улмаар сургалт, хөдөлмөрийн арга барил, дадал чадварыг эзэмшүүлэх, суллагдан гарсны дараа сургалт, хүмүүжлийн тусгай хөтөлбөрт түр хугацаагаар хамрагдах боломжийг бүрдүүлэх.

2.3. Сангийн хөрөнгийг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13².6-д заасан зориулалтаар зарцуулдаг байна. Үүнд:

13².6.1. архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах; 13².6.2. архины хэрэглээ, түүнээс үүдэн гарах хүн амын өвчлөл, нас баралт, хүчирхийлэл, осол гэмтлийн нийгмийн зардал, согтууруулах ундааны үйлдвэрлэлийн эдийн засгийн ашиг, зардлын үнэлгээг судлан тогтоож, архидан согтуурахаас сэргийлэх, түүнд хяналт тавих арга замыг тодорхойлох;

13².6.3. архины хор хөнөөл, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгэмд учрах хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх болон архины зохистой, соёлтой хэрэглээг олон нийтэд төлөвшүүлэх;

13².6.4. архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх;

13².6.5. архидан согтуурах явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй оролцсон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах.

БҮЛЭГ 1. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР

1.1 Архидан согтуурахтай тэмцэх хуулийн 13.2.6 заалтын дагуу Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн даргалхаар баталсан байна.

1.2 Архидан согтуурахтай тэмцэх сан нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм”-д заасны дагуу Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголоор АСТС-ийн 2013 оны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зориулалтаар 674.5 сая төгрөг болон батлагджээ.

1.3 Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 245 дугаар тогтоолоор Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийг шинэчлэн баталсан байна. Уг дүрэмд сангийн үйл ажиллагаа явуулах жилийн төлөвлөгөө батлуулах эрх зүйн заалт оруулаагүй бөгөөд сангийн 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй байна. Харин Засгийн газрын 2004 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан АСТС-ийн хуучин дүрэмийн 4.1.1-т “Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах” гэсэн заалт байсан байна.

1.4 Энэ байдлаас үзэхэд АСТС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй мөн сангийн хөрөнгийг зарцуулах эрх зүйн үндэслэл тодорхойгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1 Архидан согтуурахтай тэмцэх сангийн санхүүжилтээр 2013 онд хийх арга хэмжээнд 11 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

АСТСангийн 2013 оны үйл ажиллагааны санхүүжилтийн хүснэгт:

д/д	Нэр	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Гэрээний хугацаа
1	ШШГЕГ	176,336,100	176,336,100		2013.12.31
2	ШШГЕГ	13,256,500	13,256,500		2014.02.01
3	Хүчирхийлэлийн үндэсний төв эсрэг	11,995,000	8,996,249	2,998,751	2014.03.30
4	Монгол өрх сэтгэл заслын холбоо ТББ	26,738,950	10,955,250	15,783,700	2014.09.15
5	Эрх зүйн стратегийн төв НҮТББ	21,900,000	15,230,000	6,670,000	2014.09.15
6	Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төв	34,790,000	34,790,000		2014.06.30
7	Сэтгэлийн анир ТББ	20,730,000	20,730,000		2014.10.01
8	Боловсрол суваг телевиз	49,500,000	49,500,000		2014.10.01
9	Боловсрол суваг телевиз	23,000,000	23,000,000		2014.12.31
10	Боловсрол суваг телевиз	49,500,000	49,500,000		2014.10.01
11	Замын цагдаагын газар	76,466,920	76,466,920		2013.12.15
12	Цагдаагийн ерөнхий газар САТГ /сургалт/	50,000,000	50,000,000		2013.12.31
13	Зөв амьдрах ухаан ТББ	57,569,000	57,569,000		2014.05.30
14	Их тэнгэр цогцолбор	17,400,000	17,400,000		тушаал
15	Хэнтий аймгийн ЗДТГ	20,000,000	20,000,000		тушаал
16	Үндэсний шуудан сонин	80,000	80,000		
17	Үндэсний шуудан сонин	160,000	160,000		
18	Керамакс ХХК	77,530	77,530		
19	Үндэсний шуудан сонин	5,000,000	5,000,000		2014.12.31
20	Ньюс Аженси ХХК	10,000,000	10,000,000		2014.12.25
21	Ардчилал сонин	10,000,000	10,000,000		2014.12.31
	Нийт	674,500,000	649,047,549	25,452,451	

2.2 Аудитаар Архидан согтуурахтай тэмцэх сангийн санхүүжилтаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас дурьдвал:

2.3 ХЗЯ-аас ШШГЕГ-тай байгуулсан “Архины хамааралтай этгээдийн зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ”-ний дагуу бэлэн мөнгөөр 82.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2¹ дахь заалттай нийцэхгүй байна.

¹ Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ (ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд:

ЖБТ 0-100,000,000 хүртэлх төгрөг	-ЖМС 0-500,000 төгрөг
ЖБТ 100,000,001-1,000,000,000 хүртэлх төгрөг	-ЖМС 500,000-1,500,000 төгрөг
ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш	-ЖМС 1,500,000- 3,000,000 төгрөг

2.4 **”Сэтгэлийн анир”** ТББ нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хороодын засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаагийн албан хаагч нартай хамтран тухайн нутаг дэвсгэрийн ард иргэдэд төслийн үйл ажиллагааны талаар болон архины хор хөнөөл, зохисгүй хэрэглээг таниулан сурталчилж, архи хэтрүүлэн хэрэглэгч, эрсдэлтэй хэрэглэгчийг илрүүлэх, тэдэнд хэрэгцээтэй сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг хүргэх ажлыг 45 хувийн үр дүнгийн биелэлттэй зохион байгуулан гүйцэтгэжээ.

2.5 **”Зөв амьдрах ухаан”** ТББ нь Архидан согтуурсан үедээ гэмт хэрэг хийж хорих ял эдэлж, улмаар хорих ангиас суллагдан гарсан иргэдийг нийгэмшүүлэх, түр байрлуулах, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хийх, баримт бичигтэй болгох, ажлын байранд зуучлах үйл ажиллагаа явуулахаар 57,569,000 төгрөгийн гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгожээ.

2.6 **”Монгол өрх”** ТББ нь Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад эрхээ хасуулсан жолооч нарт давтан сургалтыг Нийслэл болон 11 аймагт зохион байгуулах гэрээ байгуулан нийт 26,738,950 төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

”Тамхи, архины шалтгаант эмгэг судлалын төв” ТББ

2.7 Архинаас гарсан эрчүүдийн аялал чуулганыг 11 аймаг 40 сумын хүрээнд зохион байгуулах, хууль эрх зүй, нотолгоонд суурилсан туршлагын уулзалт зохион байгуулах бүлэг бэлтгэх, эрүүл идэвхитэй амьдрал клубүүдийн орон нутгийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зохион байгуулах чиглэлээр гэрээ байгуулан ажилжээ. Төслийн нийт хэрэгжилт нь 70 хувьтай байгаа бөгөөд гэрээний санхүүжилт болох 34,8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Эрх зүйн стратегийн төв, “Амьдралын аваргуудын эхлэл сан” хамтарсан ТББ

2.8 Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах сургалтын гарын авлага бэлтгэж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр гэрээ байгуулан ажилжээ. Төслийн нийт хэрэгжилт нь 69.5 хувьтай байгаа бөгөөд гэрээний санхүүжилт болох 21,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

”Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ

2.9 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга зүйг хөгжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр гэрээ байгуулан ажилжээ. Төслийн гэрээний санхүүжилт болох нийт 11,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

2.10 АСТС-ийн үйл ажиллагааны хүрээнд дээрх сонгон шалгаруулалтад шалгарсан “Сэтгэлийн анир”, “Тамхи, архины шалтгаант эмгэг судлалын төв” зэрэг

төрийн бус байгууллагуудад хамтран ажиллах гэрээний заалтыг зөрчин гэрээний дагуу ажлаа бүрэн дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Их тэнгэр цогцолбор

2.11 Их тэнгэр цогцолборт ХЗЯ-ны ТНБ-ийн даргын 2013 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах тухай” арга хэмжээнд шаардагдах зардлыг Архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгөнөөс санхүүжүүлсэн нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13² дугаар зүйлийн 13².6.1-д заасан “архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах” гэсэн заалтыг зөрчиж санхүүжилт олгосон байна.

2.12 Архидан согтуурахтай тэмцэх сангийн үйл ажиллагааны хүрээнд 11 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийсэн гэрээний хугацаа нь он дамжсан байна. Мөн сангийн 2013 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гараагүйгээс сангийн үйл ажиллагааны үр дүнг тооцох боломжгүй байна.

БҮЛЭГ 3. САНГИЙН УДИРДЛАГА БОЛОН ТАВИХ ХЯНАЛТЫН ТАЛААР

3.1 ЗГ-ын 2013 оны 245 дугаар тогтоолоор баталсан АСТС-ийн дүрмийн 3 дугаар заалтын 3.1-т “Сангийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

1. Сангийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг шалгаруулах;
3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, тайланг хэлэлцэх.

3.2 2013 онд АСТСан 11 аж ахуйн нэгж, ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ.

3.3 Аудитын явцад Хууль зүйн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/91 дүгээр тушаалын дагуу архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журам болон сонгон шалгаруулалтын комиссыг баталсан байна.

3.4 Гэвч АСТСангийн удирдах зөвлөл нь сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтыг хийгээгүй байна.

3.5 АСТСангийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд ХЗЯ-аас дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь АСТС-ийн дүрмийн 3 дугаар заалтын 3.1.3-т заасан “Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, тайланг хэлэлцэх” гэсэн заалтийг биелүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт

Аудитаар илрүүлсэн нотлох зүйлс, дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Засгийн газрын тусгай сангийн хуульд АСТС-ийн эрх зүйн орчин тусгаагүй зөвхөн ХЗСайдын мэдэлд сангийн үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

2. Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 245 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан сангийн дүрэмд Хууль зүйн сайд зөвлөлийг ахалж, зөвлөлийн шийдвэрээр жилийн төлөвлөгөөг батлах байсан боловч сангийн 2013 оны төлөвлөгөөг боловсруулж батлаагүй байна.

3. АСТСангийн үйл ажиллагааны хүрээнд 11 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийсэн гэрээний хугацаа нь он дамжсан байна. Мөн сангийн 2013 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гараагүй байгаа нь сангийн үйл ажиллагааны үр дүнг тооцох боломжгүй байна.

4. АСТС-ийн үйл ажиллагааны хүрээнд дээрх сонгон шалгаруулалтад шалгарсан “Сэтгэлийн анир”, ”Тамхи, архины шалтгаант эмгэг судлалын төв” зэрэг төрийн бус байгууллагуудад хамтран ажиллах гэрээний заалтыг зөрчин гэрээний дагуу ажлаа бүрэн дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

5. АСТСангийн удирдах зөвлөл нь сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгон ажиллаагүй байна.

6. АСТСангийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд ХЗЯ-аас дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь АСТС-ийн дүрмийн 3 дугаар заалтын 3.1.3-т заасан “Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, тайланг хэлэлцэх” гэсэн заалтыг биелүүлж ажиллаагүй байна.



**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26-75-33, E-mail: foreign@moj.gov.mn,
http://www.moj.gov.mn

2014.07.07 № 3/2846
танай 2014.07.01 -ны № 911 -Т

Санал өгөх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР А.ЗАНГАД
ТАНАА

Танаас Хууль зүйн сайдын нэр дээр ирүүлсэн 2014 оны 911 тоот албан бичгийн хавсралт "Архидан согтуурахтай тэмцэх сангийн үйл ажиллагаа, үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн төсөл, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаад дараах саналтай байна. Үүнд;

Дүгнэлт 1. Засгийн газрын тусгай сангийн хуульд АСТС-гийн эрх зүйн орчин тусгаагүй зөвхөн Хууль зүйн сайдын мэдэлд сангийн үйл ажиллагааг зохион байгуулж явуулдаг байна.

Дүгнэлт 1-д өгөх тайлбар. Архидан согтуурахтай тэмцэх сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн ажлын хэсгийг Хууль зүйн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн А/228 тушаалаар "Ажлын хэсэг" байгуулан ажиллаж, Согтууруулах ундааны хяналтын тухай хууль болгон шинэчлэн найруулж, уг хуулийн төсөлд Архидан согтуурахтай тэмцэх санг Засгийн газрын Тусгай сангийн тухай хуульд нэмж оруулахаар хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар оруулж хэлэлцүүлсэн боловч, Засгийн газрын хуралдаанаас тодорхой үүрэг өгч буцаагдсан.

Дүгнэлт 2. Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан сангийн дүрэмд Хууль зүйн сайд зөвлөлийг ахалж, зөвлөлийн шийдвэрээр төлөвлөгөөг батлах байсан боловч, Сангийн 2013 оны төлөвлөгөө батлаагүй байна.

Дүгнэлт 2-т өгөх тайлбар. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Засгийн газрын 2013 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан "Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм"-д сангийн үйл ажиллагааг явуулах жилийн төлөвлөгөө батлах талаар заалт байхгүй боловч 2014 оны төлөвлөгөөг боловсруулан Сангийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

Дүгнэлт 3. АСТС-гийн үйл ажиллагааны 11 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийсэн гэрээний хугацаа нь он дамжсан байна. Мөн Сангийн 2013 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гараагүй байгаа нь сангийн үйл ажиллагааны үр дүнг тооцох боломжгүй байна.

Дүгнэлт 3-т өгөх тайлбар. Засгийн газрын 2013 оны "Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм" 245 дугаар тогтоол нь 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсантай бөгөөд сангийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнд Хууль зүйн яамны дотоод хяналт хийгдээгүй нь тухайн төрийн бус байгууллагуудтай хийсэн гэрээний хугацаа дуусаагүй байсантай холбоотой.

C:\Documents\yam.A-4 2014.doc

08 2429

Дүгнэлт 4. АСТС-ийн үйл ажиллагааны хүрээнд сонгон шалгаруулалтад шалгарсан "Зөв амьдрах ухаан", "Монгол өрх", "Сэтгэлийн анир", "Тамхи, архины шалтгаант эмгэг судлалын төв", "Эрх зүйн стратегийн төв", "Амьдралын аваргууд эхлэл сан хамтарсан", "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" зэрэг 6 төрийн бус байгууллагуудад хамтран ажиллах гэрээний заалтыг зөрчин гэрээний дагуу ажлаа бүрэн дуусаж хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Дүгнэлт 4-т өгөх тайлбар. Засгийн газрын 2013 оны "Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм" 245 дугаар тогтоол нь 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан тул дээрх төрийн бус байгууллагуудтай байгуулсан гэрээний үйл ажиллагааны явцтай танилцан гэрээний санхүүжилтийг 2013 онд олгож ажилласан.

Дүгнэлт 5. АСТС-гийн үйл ажиллагааны хүрээнд ШШГЕГ-ын тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 82.9 сая төгрөг, Замын цагдаагийн газар багаж хэрэгсэл худалдан авахад 52.6 сая төгрөг, нийт 135.5 сая төгрөгийг сангийн хөрөнгөөс зориулалт бусаар зарцуулсан байна.

Дүгнэлт 5-д өгөх тайлбар. Засгийн газрын 2014 оны 245 дугаар тогтоолын дагуу Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн хурлыг 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Хууль зүйн яамны 102 тоот хурлын зааланд хийж, 2012 онд тус санд батлагдсан хөрөнгийг 100 хувь төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин олгож, тухайн төрийн бус байгууллагууд нь архины хамаарлаас гарч нийгэмших шатандаа яваа иргэдэд архины хамаарлаас гарах сургалтын клуб байгуулсан талаар танилцуулсан.

Харин 2013 оны хувьд төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ хуулиар архидан согтуурахтай тэмцэх чиг үүрэг бүхий тус яамны харьяа төрийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих асуудлыг сангийн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн бөгөөд нийт 11 төрийн бус байгууллага болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газар, Архидан согтуурсан этгээдийг түр саатуулах төвийн үйл ажиллагааг дэмжин тус тус гэрээ байгуулан хамтран ажилласан болно.

Мөн сангийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.4-т "архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг судалж, архины хамааралтай сөрөг зан үйлд нь нөлөөлөх, улмаар сургалт, хөдөлмөрийн арга барил, дадал чадварыг эзэмшүүлэх, суллагдан гарсны дараа сургалт, хүмүүжлийн тусгай хөтөлбөрт түр хугацаагаар хамрагдах боломжийг бүрдүүлэх" гэж заасан байгаа болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай байгуулсан "Архины хамааралтай этгээдийн зан үйлд нөлөөлөх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ"-ний хэрэгжилтийг хангалтгүй, зарцуулалт тодорхой бус, төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сулаас Төсвийн тухай хуулийн 6.4.1, 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7, 19.1.3, 19.1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн гэж үзэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д заасны дагуу 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 02/60YAГ/CAГ/2014/17/TEЗ дугаарын "Зөрчил арилгуулах тухай" албан шаардлагыг ахлах аудитор Б.Болормаа өгсөн.

Зөвлөмж 4. Хууль, дүрэм зөрчсөн холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох гэсэн хэсэгт өгөх тайлбар.

Хууль зүйн яамны зүгээс Архидан согтуурахтай тэмцэх сангийн үйл ажиллагааг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль эрх зүйн акттай нийцүүлэн ажиллаж байгаа гэж үзэж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

Танай газраас уг асуудлыг тавихаас өмнө тус санг хариуцсан мэргэжилтэн нь Засгийн газрын 2004 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрэм"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан батлуулахаар ажиллахдаа ажлыг удаашируулсантай холбогдуулан ажлаас нь чөлөөлсөн тул зөвлөмжийн 4 дэх хэсгийг хасуулах саналтай байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.БАЯРЦЭЦЭГ

C:\Documents\yam.A-4 2014.doc

Зөвлөмж

Аудитын дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд:

1. Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг сангийн тухайн жилийн төлөвлөгөөг Сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, батлагдсаны дараа зохион байгуулах;
2. Сангийн хөрөнгийг томоохон үр дүнтэй арга хэмжээнд зориулахад анхаарч, төлөвлөлтийг боловсронгуй болгож, үйл ажиллагааны хяналтыг сайжруулах;
3. Засгийн газрын тусгай сангийн хуульд хуульчлан оруулж, Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсүгэй.

4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хамжээ авч, үр дүнг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД